

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2019 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ
ЧУУЛГАНЫ ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
10 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР /ПҮРЭВ ГАРАГ/-ИЙН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН ТОВЬЁГ**

№	Баримтын агуулга	Хуудасны дугаар
1	Хуралдааны товч тэмдэглэл	1-2
2	Дэлгэрэнгүй тэмдэглэл 1.“Ард нийтийн санал асуулга явуулах, Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн эхийг батлах тухай” Улсын Их Хурлын 2019 оны 73 дугаар тогтоолд бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хориг	3-25 3-25

**Монгол Улсын Их Хурлын 2019 оны намрын ээлжит
чуулганы Төрийн байгуулалтын байнгын хорооны
10 дугаар сарын 03-ны өдөр /Пүрэв гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга С.Бямбацогт ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 12 гишүүн ирж, 63.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 16 цаг 57 минутад Төрийн ордны “В” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Б.Жавхлан, Л.Оюун-Эрдэнэ, Н.Цэрэнбат, О.Содбилэг, Б.Наранхүү.

Нэг. “Ард нийтийн санал асуулга явуулах, Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн эхийг батлах тухай” Улсын Их Хурлын 2019 оны 73 дугаар тогтоолд бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хориг

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга З.Энхболд оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Э.Түвшинжаргал, Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ж.Бямбадулам, зөвлөх А.Солонго, референт Ж.Ганчимэг нар байлцав.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тавьсан хоригийн талаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга З.Энхболд танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан, Ж.Мөнхбат, Д.Эрдэнэбат нарын тавьсан асуултад Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга З.Энхболд нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүү, Д.Хаянхярваа, Д.Эрдэнэбат, Н.Энхболд, Ж.Мөнхбат нар үг хэлэв.

С.Бямбацогт: “Ард нийтийн санал асуулга явуулах, Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн эхийг батлах тухай” Улсын Их Хурлын 2019 оны 73 дугаар тогтоолд бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авах нь зүйтэй гэсэн саналаар санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн 5

Татгалзсан 8

Бүгд 13

38.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбат Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Хуралдаан 1 цаг 17 минут үргэлжилж, 19 гишүүнээс 13 гишүүн ирж, 68.4 хувийн ирцтэйгээр 18 цаг 07 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

С.БЯМБАЦОГТ

Тэмдэглэл хөтөлсөн:
ПРОТОКОЛЫН АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Д.ЦЭНДСҮРЭН

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2019 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ 10 ДУГААР САРЫН
03-НЫ ӨДРИЙН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ**

С.Бямбацогт: 2019 оны 10 дугаар сарын 3-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье. Ирвэл зохих 19 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирсэн байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Ард нийтийн санал, асуулга явуулах. Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн эхийг батлах тухай Улсын Их Хурлын 2019 оны 73 дугаар тогтоолд бүхэлд нь хориг тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулж саналтай гишүүн байна уу. Алга байна. Хэлэлцэх асуудалд оръё.

Ард нийтийн санал асуулга явуулах Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн эхийг батлах тухай Монгол Улсын Их Хурлын 2019 оны 73 дугаар тогтоолд бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хориг хэлэлцье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 31.2 дахь хоригийн анх тухайн асуудлыг хэлэлцэж, санал дүгнэлт гаргасан холбогдох Байнгын хороо болон Хууль зүйн байнгын хороо хэлэлцэж санал дүгнэлт гаргана. 31.4-т Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаан дээр гишүүд Ерөнхийлөгчийн хориг болон Байнгын хорооны санал дүгнэлттэй холбогдуулж асуулт, асууж үг хэлж болно.

Ард нийтийн санал асуулга явуулах Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн эхийг батлах тухай Улсын Их Хурлын 2019 оны 73 дугаар тогтоолд бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Энхболд танилцуулна.

Энхболд даргыг микрофонд урьж байна. 1 дүгээр микрофон.

3.Энхболд: Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүдэд энэ өдрийн мэнд хүргэе.

Монгол Улсын Ерөнхийлөгч 2019 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн Е/44 тоот албан тоотоороо Улсын Их Хурлын шийдвэрт хориг тавьсан. Уг хоригийг танилцуулъя.

Ард нийтийн санал асуулга явуулах, Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн эхийг батлах тухай Улсын Их Хурлын 2019 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн 73 дугаар тогтоолыг 2019 оны 9 дүгээр сарын 13-ны өдөр Ерөнхийлөгчийн Тамгын газарт ёсчлон ирүүлсэнтэй танилцлаа.

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үйл ажиллагааг Хууль зүйн зөрчил маргаангүй явуулбал зохих талаар миний бие 2019 оны 6 дугаар сарын 11-ний өдөр Е/37 дугаар албан бичгээр Улсын Их Хуралд сануулан удаа дараа анхааруулсан боловч үл ойшоон хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийг илэрхий зөрчсөн байдлаар Үндсэн хуулийн асуудалд хандсаныг хүлээн зөвшөөрөх аргагүй байна.

Хууль ёсыг чанд баримталж, нийгмийн зөвшилцөл, ойлголцлын хүрээнд явуулах ёстой Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн асуудал, хэн нэг нам хүч түрэмгийлэн дур зоргын байдлаар хандах нь сайн зүйл авч ирдэггүйг 2000 оны нэмэлт, өөрчлөлтүүд бүрэн харуулсан. Тодруулбал: 2000 оны нэмэлт, өөрчлөлтийг олон нийт дордуулсан долоон өөрчлөлт хэмээн нэрлэж, Үндсэн хуульд орсон цагаас нь хойш өнөөг хүртэл шүүмжилж ирлээ.

Энэ удаагийн оролдлого ч мөн дордуулсан долоон өөрчлөлтийг засна гэсэн уриа лоозонтойгоор эхэлж үл бүтэх байдлаар өрнөлөө. МАН Улсын Их Хуралд үнэмлэхүй олонхын суудал авч, төрийн эрхийг дангаар барьж байх үедээ Үндсэн хуульд дордуулсан долоон өөрчлөлтийг оруулсан байдаг бөгөөд уг өөрчлөлт улс орны хөгжил, улс төр нийгмийн амьдралд сөрөг муу нөлөө үзүүлсэн тухай шүүмжлэл өнгөрсөн хугацаанд тасраагүйтэй адил тухайн өөрчлөлтийг оруулах үед явагдсан хууль тогтоох байгууллагын хуулийн зөрчил бүхий үйл ажиллагаатай холбогдсон маргаан бас тасраагүй гэж хэлж болно.

Тодотговол Улсын Их Хурал хууль болон тогтоол гаргаж байхаар заасан тухайн үеийн хуулийн тодорхой зохицуулалтыг зөрчиж, 2000 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хууль хэлбэрээр батлаагүйтэй холбогдон үүссэн маргаан, Үндсэн хуулийн цэцийн хэмжээнд олон жил өрнөсөн байх бөгөөд үүний үр дүнд Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хууль батлагдсан хэмээн дүгнэж болохоор байна.

2010 оны 12 дугаар сарын 23-ны өдөр батлагдсан энэхүү журмын тухай хууль нь зарим маргааныг бүрэн цэглэсэн Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбогдсон харилцаа, аливаа үйл ажиллагааг нэг бүрчлэн зохицуулсан, чандлан мөрдвөл зохих хууль болсон.

Тиймээс Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үйл ажиллагааг энэ хуульд бүрэн нийцүүлж, хууль зүйн зөрчил, маргаангүйгээр шийдвэрлэх нь зүй ёсны шаардлага болно. Харамсалтай нь Улсын Их Хурлын 2019 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн 73 дугаар тогтоолоор батлагдсан ард нийтийн санал

асуулгад оруулах Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн эх нь Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн зохих шаардлагыг хангаагүй, уг хуулийг илэрхий зөрчсөн байдалтай байна. Тухайлбал:

1. Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.4-т Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэлбэр нь зөвхөн хууль байна гэж заасан бол тус хуулийн 6 дугаар зүйлийн Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахад хууль санаачлах, 7 дугаар зүйлийн Ерөнхийлөгч Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах хууль санаачлах, 8 дугаар зүйлийн Улсын Их Хурлын гишүүн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах хууль санаачлах, 9 дүгээр зүйлийн Засгийн газар Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах хууль санаачлах, 10 дугаар зүйлийн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд тавих шаардлага, 11 дүгээр зүйлийн Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэх зэрэг зохицуулалтууд нь бүхэлдээ Үндсэн хуульд зөвхөн хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулна гэдгийг бататган холбогдох харилцааг хоёрдмол утгагүйгээр туйлын тодорхой зохицуулжээ. Хуулийн ийм тодорхой шаардлага зохицуулалтуудыг Улсын Их Хурал илэрхий зөрчиж Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийг хууль хэлбэрээр хэлэлцэн шийдвэрлээгүй бөгөөд энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн хоёр дахь хэсгийн хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим, мөн 70 дугаар зүйлийн нэг дэх хэсгийн Үндсэн хуульд зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино гэсэнд огт нийцэхгүй байгаагаас гадна улс орны тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын баталгаа болсон гол хуульд хууль зөрчсөн байдлаар өөрчлөлт оруулж, нийгмийн зөрчил маргааныг улам дэвэргэх шалтгаан нэмж, энэ туйлаас зохимжгүй мөн болно гэж дүгнэж байна. Түүнчлэн Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахад баримтлах ёстой гол хуулийг илэрхий зөрчсөн Улсын Их Хурлын энэхүү үйл ажиллагаа нь Монгол Улсын Үндсэн хуульд байгуулалд халдсан хэрэг болох тул нийгэмд томоохон эсэргүүцэл, тэмцэл бий болгож, улс орныг бүхэлд нь хямрааж мэдэхээр эрсдэлтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсэгт энэ хуулиас гадна Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахыг завдах, хуйвалдан оруулах аливаа үйлдлийг Монгол Улсын Үндсэн хуульд байгуулалд халдсан хэрэг гэж үзнэ гэж маш тодорхой заасныг Монгол Ардын Нам түүнээс сонгогдсон Улсын Их Хурлын гишүүд онцгойлон үзэж анхаарвал зохино.

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.4-т заасан Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэлбэр нь зөвхөн хууль байна гэсэн шаардлагыг зөрчсөн. Үүнээсээ улбаалан тухайн хуулийн олон зүйл заалтыг мөн зөрчөөд байгаа Улсын Их Хурлын үйл ажиллагааг хуулиас гадуур үйлдэл гэж үзэхээс өөр аргагүй бөгөөд хууль ёсыг үгүйсгэсэн Үндсэн хуульд байгуулалд халдсан ийм үйл ажиллагаанд нийт ард түмнийг татан оролцуулахыг хүлээн зөвшөөрөх боломжгүй юм.

2. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэлбэр нь зөвхөн хууль

байна гэсэн хуулийн шаардлагыг зөрчиж, Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлтийн төсөл өргөн мэдүүлсэн Лүндээжанцан нарын гишүүд Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.4-т заалтаас гадна 6 дугаар зүйлийн 6.1, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийг тус тус зөрчсөн бол хууль зүйн шаардлага хангаагүй төслийг хүлээн авч хэлэлцсэнээр Улсын Их Хурал мөн Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 10 дугаар зүйлийг зөрчсөн гэж үзэж байна. Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 10 дугаар зүйл нь Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд тавигдах шаардлагыг тогтоосон бол тус зүйлийн 10.1 дэх хэсэгт Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төсөл нь дор дурдсан нийтлэг шаардлагыг хангасан байна. 10.1.1-д Үндсэн хуулийн зохих зүйл болон энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан зарчимд бүрэн нийцэж байгаагүй буюу харшлаагүйг нотолсон тайлбар хавсаргасан байна гэж заасан байдаг. Мөн тухайн хуулийн 5 дугаар зүйлд Улсын Их Хурал болон хууль санаачлагч Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үйл ажиллагааны бүх үе шатанд 3 үндсэн зарчим баримтална. Эдгээр 3 зарчмын нэг нь Үндсэн хуулийг дээдлэн сахих, түүний тогтвортой байдлыг хамгаалах зарчим байна гэж заасан бөгөөд энэ зарчмыг Үндсэн хуульд зөвхөн хуулиар нэмэлт өөрчлөлт оруулах зэрэг заавал хэрэгжүүлэхээр шаардсан 4 төрлийн арга замаар хангаж хэрэгжүүлэхээр хуульчилсан.

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбогдсон Улсын Их Хурлын үйл ажиллагааны хүрээнд хуулийн дээрх зарчим, шаардлагууд бүрэн зөрчигдөөд байна.

Тиймээс төсөл өргөн мэдүүлэх, хүлээн авах болон хэлэлцэн шийдвэрлэхтэй холбогдсон Улсын Их Хурлын үйл ажиллагааг бүхэлд нь хууль бус буюу хууль бусаар явагдсан гэж дүгнэхээс өөр аргагүй байна.

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4.1-д Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санаачилга, үйл ажиллагаа нь дур зоргын шинжтэй байж болохгүй гэж заажээ.

3. Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг Үндсэн хуулийн 68 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтан Улсын Их Хуралд өргөн мэдүүлж болно. 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт Улсын Их Хурлын гишүүн Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хууль санаачилж болно гэж заасан бол мөн хуулийн 10 дугаар зүйлээр Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд тавих шаардлагыг 11 дүгээр зүйлээр Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэх журмыг тус тус хуульчлан тогтоожээ.

Хуулийн эдгээр зохицуулалт Үндсэн хуульд зөвхөн хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулна гэдэг нь маргаангүй үйлдлээр хэлсэн бол ард нийтийн санал асуулгаар Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмыг тогтоосон Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 17 дугаар зүйлээр улам бататгасан байна. Тухайлбал тус хуулийн 17 дугаар

зүйлийн 8 дахь хэсэгт ард нийтийн санал асуулгад сонгогчдын нэрсийн жагсаалт хууль бусаар оролцсон нийт иргэдийн олонх нь оролцож, тэдгээрийн олонх нь уг хуулийг зөвшөөрнө гэж санал өгсөн бол Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсан тооцно.

17 дугаар зүйлийн 17.9 дэх хэсэгт ард нийтийн санал асуулгаар батлагдсан хуулийг албажуулах, нийтлэх хүчин төгөлдөр болсонд тооцох асуудлыг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо зохион байгуулна. 17 дугаар зүйлийн 17.10 дахь хэсэгт ард нийтийн санал асуулгаар батлагдсан хуульд Улсын Их Хурал ямар нэгэн засвар өөрчлөлт оруулах, Үндсэн хуулийн Цэц хянан шийдвэрлэхийг хориглоно гэж тус тус заасан. Эдгээр зохицуулалтууд ард нийтийн санал асуулгаар Улсын Их Хурал хэлэлцсэн хуулийн төслөө оруулж дэмжигдсэн тохиолдолд тухайн төсөл нь хууль болон батлагдана гэдгийг тодорхой зааж байгаагүй бөгөөд Улсын Их Хурлын 2019 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн 73 дугаар тогтоолоор батлагдсан ард нийтийн санал асуулгад оруулах Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн эх нь хуулийн энэ тодорхой шаардлагыг огт хангасангүй.

Ард нийтийн санал асуулгыг хууль зүйн ийм илэрхий зөрчилтэйгөөр явуулж, ард түмнийг хууль бус үйл ажиллагаанд татан оролцуулах нь Үндсэн хуулийн дархлааг үгүй хийх, хууль дээдлэх ёсыг устгах, улмаар улс орны аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэх муу үр дагавартай тул зөвшөөрөх аргагүй юм.

4. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэгт Улсын Их Хурал хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр гаргах бөгөөд бусад шийдвэр нь тогтоолын хэлбэртэй байна гэж заасан. Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.4-ийн Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хэлбэр нь зөвхөн хууль байна гэсэн заалт зөрчигдсөнөөр хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн гэсэн Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн хоёр дахь хэсэг, түүнчлэн дээр дурдсан Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг тус тус зөрчигдсэн гэж үзэж байна.

5. Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэгт Улсын Их Хурал төслийг энэ хуулийн 14 дүгээр зүйлд зааснаар хэлэлцээд тухайн нэмэлт, өөрчлөлтийг ард нийтийн санал асуулгаар оруулах нь зүйтэй гэж үзвэл Улсын Их Хурал нь нийт гишүүний гуравны хоёроос доошгүй саналаар тогтвол Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 16 дахь заалт, 68 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ард нийтийн санал асуулга явуулах тухай тогтоол гаргана гэж заажээ.

Гэтэл Улсын Их Хурал 2019 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн 73 дугаар тогтоолыг батлахдаа Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 16 дахь заалтыг үндэслэхгүй орхиж зөвхөн 68 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэсэн, мөн түүнчлэн ард нийтийн санал асуулгын тухай хуулийг огт үндэслээгүй орхигдуулсан байгаа нь хууль зүйн зөрчлөөр төдийгүй, цаашид гаргах сөрөг үр дагавар ихтэй шийдвэр гэж үзэхээс өөр аргагүйд хүргэж байна.

Ард нийтийн санал асуулгыг Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 3 дугаар бүлгээс гадна ард нийтийн санал асуулгын тухай хуулийн хүрээнд зохион байгуулж явуулах шаардлагатай гэдгийг Монгол улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 16 дахь заалт, 68 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ард нийтийн санал асуулгыг явуулах тухай тогтоол гаргана гэсэн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг бүрэн тодорхой илэрхийлсэн байна.

Иймд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон ард нийтийн санал асуулгыг явуулах үйл ажиллагааг хуульд нийцүүлэх шаардлагатай гэж үзэн Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 8 дэх хэсгийг тус тус үндэслэн Улсын Их Хурлын 2019 оны 9 дүгээр сарын 11-ний 73 дугаар тогтоолд бүхэлд нь хориг тавьж байна.

Энэхүү хоригийг зохих хууль журмын дагуу хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү. Монгол Улсын Ерөнхийлөгч Халтмаагийн Баттулга.

С.Бямбацогт: Энхболд даргад баярлалаа. Хоригийн танилцуулга хийлээ.Танилцуулгатай холбогдуулж асуух асуулттай гишүүд байвал нэрсээ өгье. Эрдэнэбат гишүүнээр асуулт асуух гишүүдийн нэрсийг тасаллаа. Лүндээжанцан гишүүн асуултаа асууя.

Д.Лүндээжанцан: Би Ерөнхийлөгчийн хориг бол энэ дээр ирэхгүй байх гэж бодож байсан. Яагаад гэхээр нэрийн асуудал дээр 4 парламент дамжиж яригдаад, тэгээд яг нэрийг нь яаж өгөх вэ, яг 2010 оны Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын хуулийн дагуу Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлтийг хуулийн хэлбэртэй байна гээд, үүнийгээ барих уу гэж би өөрөө их гаргаж тавьдаг хүн байсан. Ингээд судлаачид, хуульчид ажлын хэсгийнхэн, үе үеийн парламенттай шүү дээ, ярьсаар байгаад 2015 онд гэхэд Нямжавын Батбаяраар ахлуулсан ажлын хэсэг ажилласан. Гончигдорж дарга гээд цөм байсан. Ингээд хууль гэх юм бол бид Үндсэн хуулиа барих нь зүйтэй юм. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөрөө явахгүй бол хууль гээд явчих юм бол Үндсэн хуультай зөрчилдөөд, энэ хэсэг заалт нь Үндсэн хуультай зөрчилдөөд байна гэж хуульчид үзээд байдаг байхгүй юу. Яагаад гэвэл Үндсэн хууль нь дотроо Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг гэж, ингэж дөрөвний гурваар батлах, тэр нь Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт нь 69 дүгээр зүйлийн 4-т байгаа, Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт Үндсэн хуулийн нэгэн адил хүчинтэй байна гээд заасан, үүнтэйгээ зөрчилдөөд байгаа учраас оруулахаас өөр аргагүй юмаа гээд. Үүнийг Үндсэн хуулийн цэцэд тухайн үедээ хүн хандаж байсан, түүнийг нь Улсын Их Хурлын баталсан хууль гээд үүсгээгүй орхисон юм билээ. Энэ үүсгээгүй орхисон юм чинь ингээд цэц гайгүй болов уу гэсэн, яг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт гэхгүй хууль гэх юм бол Үндсэн хууль, Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт бол конституционный акт, өөрөөр хэлбэл Үндсэн хуулийн шинжтэй акт, наад хууль гэхээрээ бол законы акт хууль, ердийн хууль үндсэн хууль хоёр огт өөр ялгаатай, тийм учраас Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт гэхээсээ өөр аргагүй юмаа гэдэг ийм шийдэлд хүрсэн.

Энэ хуулийг, бас энэ нэмэлт, өөрчлөлтийг ярьж эхэлсэн цагаас эхлээд

одоогоос бараг 3 жилийн өмнө шахуу эхлээд л нэр нь дээрээ 3 хоногийн яриа болсон, бүх намуудын төлөөлөл байж байгаад л, Эрдэнэбат дарга байсан л даа тухайн үедээ, одоо яах юм ,юу гэж хэлэх юм байгаа юм, үүн дээр яах вэ гээд тал талаасаа ярьсан. Тэгээд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт, хэрэв хууль гэх юм бол энэ болохгүй шүү, ёстой жинхэнэ нөгөө хориг гэж яриагүй л дээ, Үндсэн хуулийн Цэц дээр очоод балрах юм байгаа юм гэж, Үндсэн хууль дотор Улсын Дээд шүүх, шүүх бол Үндсэн хуультай зөрчилдсэн хуулийн заалтыг хэрэглэхгүй гэж Үндсэн хууль дотор бичсэн байгаа юм.

Хэрвээ Их Хурлаас баталсан хууль дотор ийм заалт байгаа юм, Үүнийг засахгүй яасан юм бэ гэсэн асуудал яригдаж мэднэ. Засах гэхээр Нямбаатар гишүүн бол өргөн үзэл баримтлалаар ,саналуудаа аваад явсан. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын хуулийг хамаагүй өөрчлөх юм бол нэг л зад тавих юм бол хаших юмгүй болоод тэгээд Үндсэн хуульд байгуулалд халдах ийм нүх сүв болно гээд улс төрийн акт хийх гээд, ингээд байдал их хүндэрсэн шүү дээ. Тухайн үедээ үүнийг чинь бид харин энэ хууль байж байж, бусад Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт журмын хуульд цоож их байгаа, гэхдээ үүний хүчээр бас нэг хашсан хэлбэртэй явж ирж байгаа юм. Ийм нөхцөл байдал үүссэн юм.

Хоёр дахь гол асуудал бол 25-ийг татах гэхээр манай хуульчид юу гэж тайлбарласан вэ гэхээр,/...минут дууссан/

С.Бямбацогт: Лүндээ гишүүний минутыг сунгая,

Д.Лүндээжанцан: Давхардуулдаггүй юмаа. Өөрөөр хэлбэл Үндсэн хуулийн 68 дугаар зүйлийн 2-т Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар Улсын Их Хурлын гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар ард нийтийн санал асуулга явуулж болно.Санал асуулгыг Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1.16-д заасан үндэслэлийн дагуу явуулна гээд, 68 дугаар зүйл дээр заасан.Тэгэхээр энэ дотроо 68 дээрээ ишилсэн байгаа учраас ард нийтийн санал асуулга явуулах гэдгийг давхардуулж заахгүй гэдэг ерөнхий зарчмаа бариад нарийвчилсан зохицуулалт байхгүй бол ерөнхий хуулиа барьдаг, энэ зарчмаараа явсан юм.Тийм учраас энэ хоёр үндэслэлээс шалтгаалж, дур зоргын өөрчлөлт гэдэг юм уу Үндсэн хуульд байгуулалд халдсан гэдэг юм уу тийм зүйл байхгүй гэдгийг одоо ойлгохгүй байна уу, манай гишүүд ч гэсэн надаас асуугаад байгаа юм, нэг л юм байна, та нар. /...минут дууссан/

С.Бямбацогт: За,Энхболд дарга хариулъя.

З.Энхболд: Асуулт асуугаагүй шүү дээ. Асуугаагүй биз дээ.

С.Бямбацогт: Асуугдсан.Ойлголтын зөрүү байна уу,та бас тайлбар өгөөдөх.

З.Энхболд: Лүндээжанцан гишүүн байр сууриа хамгаалж үг хэллээ. Асуусангүй. Ер нь 1999, 2000 оны өөрчлөлтөөс улбаатай 2010 онд энэ хуулийг чинь Чимид гуайн нэрээр нэрлэгдээд байдгаас биш ийм гишүүд өргөн барьж батлуулсан шүү дээ. Би одоо нэрийг нь уншаад өгье.

Бүгдээрээ тэгж яриад хэвшсэн байгаа. Би саяхан хууль зүй дээр хараад

байсан хаачив. Журмын тухай хуулийг Энхтүвшин тэргүүтэй, энэ байна. Энэ журмын тухай хуулийн төрсөн түүх нь ийм шүү дээ. 1999 онд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа 5-6 янзаар алдаа хийсэн байна. Тэгээд дахиж Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах бол хуультай болоод, дэг журамтай явъя гээд 2010 оны 10 дугаар сард хэлэлцэхийн өмнө Засгийн газраас санал авсан байгаа. Түүн дээр Улсын Их Хурлын гишүүн Ө.Энхтүвшин, Д.Лүндээжанцан, Ч.Сайханбилэг, Ц.Мөнх-Оргил, Одбаяр, Оюун, Ж.Сүхбаатар, Тэмүүжин, Д.Энхбат нарын санаачлан боловсруулсан Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн төсөлд Засгийн газраас өгөх санал дүгнэлт гээд ийм бичиг байгаа юм.

Тэр санал, дүгнэлтийн хоёрт нь хуулийн төслийн 3.3 дахь хэсэгт Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлтийн нэгэнт оруулсан бол гэдэг нь ойлгомжгүй байгаа тул Үндсэн хуульд өөрчлөлт оруулах хууль батлагдсан бол гээд өөрчлөх гээд ингээд санал өгсөн байгаа юм. Тэгээд журмын тухай хууль 2010 оны 12 дугаар сарын 23-нд гарахдаа хориг дээр үндэслэсэн эхний 4-5 үндэслэлийн эхний дөрөвт нь хууль гэж бичсэн, хууль санаачлагч бол заавал хуулийн хэлбэрээр өргөн барина, хуулийг батална, хуулийг ёсчилно гээд бүх шаардлагууд байгаа юм. Тэгэхээр энэ өөрөө Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах гэж байгаа бол энэ хуулийн дагуу яв гээд ингээд бичээд өгсөн хуулиа мөрдөхгүй, одоо бид нар өөрийнхөөрөө шийднэ гээд дур зоргоороо яваад байгааг нь дур зоргын үйл ажиллагаа гэж хэлээд байгаа юм.

Хэрвээ энэ хууль чинь Үндсэн хууль зөрчиж байгаа бол үүнийгээ хүчингүй болгоод явж болно шүү дээ. Тэр хууль гэж бичсэн хэсгүүдийг нь, тийм боломж байсаар байтал ингээд маргаантай, маргааны эх үүсвэр болгоод тавьчихлаа л даа, ялгаагүй 1999 оны хуулийг хүчингүй болгосонтой адилхан Цэц дээр очоод унахыг үгүйсгэхгүй гэж хэлээд байгаа юм. Цэц түүнээс хойш 2013 оны 10 дугаар сарын 11-ний 87 дугаар тогтоол, 2013 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 24 дүгээр магадлал гээд ийм зүйлүүдийг гаргаад, 2010 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хууль зөв хууль байна, энэ дотор хууль гэж бичигдсэн нь зөв, энэ хуулийнхаа дагуу Үндсэн хуульдаа нэмэлт, өөрчлөлт оруулаад, ингээд эцэслээд шийдсэн байгаа юм. Ариунболд гэдэг хүний гомдлын дагуу, биш ээ эхлээд Жанцан гуай, дараа нь гурвуулаа Очирбат гуай гээд бүгд, энэ тогтоолд хууль байна гэдгийг маш, 2010 оны хууль зөв гэдгийг нь баталчхаад байгаа юм. Тэгэхээр одоо 2010 оны хуулийн дагуу явагдаагүй нэмэлт, өөрчлөлтийг хууль бус гэж үзэх болчихоод байгаа юм л даа.

С.Бямбацогт: 2015 онд ч бас 47 гишүүн гарын үсэг зураад нэмэлт, өөрчлөлт гээд гарын үсэг зураад өргөн барьсан шүү дээ. Түүнийг манайхан бас мэдэж байгаа байх. Мөнхбат гишүүн асуулт асууя.

Ж.Мөнхбат: Үндсэн хууль гэдэг нийгмийн зөвшилцлийн гэрээ гээд бид нар хавар, зун, намрын 9 сар ярилаа. Зөвшилцөнө гээд баахан ярилаа, ойлголцсон, одоо асуудалгүй боллоо гээд. Тэгээд өнөөдөр бидэнд иймэрхүү ажин, түжин байдал үүсээд байна. Сая би намын бүлгийн хурал дээр санал гаргаж байсан. Ер нь энэ нэг нэр, хоёр хочтой, ард түмэнд ч гэсэн Үндсэн хууль

зөрчөөд хэдэн хүмүүс, нэг улс төрийн хүчин улайрч байгаад Үндсэн хууль баталчихсан юм шиг, эсхүл түүнийгээ чичрээд хүчээр тулгаад байгаа юм шиг ийм байдалтай байх нь буруу юм байна гэж би тэгж бодож байна. Сая энэ Журмын тухай хуулийн тэр асуудал байна. Одоо Төрийн байгуулалтын байнгын хорооны даргаас асуух уу, би эх баригчаас асууя даа. 2 хуулийн заалт байна. Яг одоо энэ Ерөнхийлөгчийн оруулж ирсэн, хориг тавьсан хууль зөрчсөн байна гэсэн ийм зүйлт яг хэр бодитой вэ нэгдүгээрт.

Хоёрдугаарт, сая Хууль зүйн байнгын хороон дээр Раднаасэд гишүүн ярьж байна. Ард нийтийн санал асуулгын тухай хуулийн 7.1-д санал асуулга явуулах тухай шийдвэрт санал асуулга явах өдрийг уг шийдвэр хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 21-45 хоногийн дотор явуулахаар Улсын Их Хурал товлон зарлана гэж байна. Уг шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш. Тэгэхээр энэ чинь санал асуулгыг явуулна гэдэг Улсын Их Хурлын шийдвэр гарснаас хойш 21-45 хоногийн дотор гэж ойлгох юм уу, эсхүл хугацаа товллоод нэг тогтоол гарна шүү дээ, түүнээсээ 21-45 гэж ингэж явуулах юм уу? Энэ дээрээ эх баригч, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга хоёроос нэгдүгээрт асууя.

Хоёрдугаарт, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Энхболдоос, одоо энэ хоригийг хүлээж авахгүй гээд ингээд цаашаа явлаа гэж бодоход энэ асуудал бол одоо Ерөнхийлөгчийн энэ хоригийг хүлээж аваагүй асуудал Үндсэн хуулийн цэц дээр очих магадлал ер нь Ерөнхийлөгчийн институтийн харж байгаагаар хэр хувьтай байна вэ, магадлал байна уу, өндөр магадлалтай байна уу?

Ер нь цаашдаа бид нар эндээс, одоо энд Ардчилсан намын зөвлөлийн дарга сууж байна. Нийгмийн зөвшилцлийн гэрээ гэдэг утгаар нь энэ асуудлаа ярьж, ойлголцоод, Энхболд даргаас асуух хоёр дахь асуулт нь, энэ тавьсан хоригийг хэсэгчилж хүлээж авах боломж байгаа юу гэсэн ийм 2 асуулт байгаа юм. Тэгээд хэсэгчилж хүлээж авдаг ч юм уу, бүтнээр нь хүлээж аваад, энэ Ардчилсан намын тавиад байгаа 3-4 зүйл байгаа юм билээ. Ерөнхий сайд кабинетын сайд нараа томилдог, хоёр дахь асуудал нь энэ тогтолцооны асуудлыг яриад байх шиг байна, гурав дахь асуудал нь, Ерөнхийлөгчийг парламентаас сонгох асуудлыг яриад байна, дөрөв дэх нь өрийн таацыг нэмэхгүй байх асуудлыг Үндсэн хуульд тусгаж өгье гэсэн ийм хэдэн зүйл яриад байх шиг байгаа юм. Эд нараас 2 зүйлийг нь аваад явчих боломж байна гэж харж байгаа юм.

Ингээд парламентын тогтолцоогоо улам сайжруулах ийм алхам хийгээд, Ерөнхийлөгч институт, Улсын Их Хурал парламент, олонх, цөөнхийн бүлэг, зөвлөл ойлголцоод ингээд энэ хоригийг хүлээж аваад, тэгээд наашаа, цаашаа гэсэн ухрах, няцах юмгүйгээр, ярьсан, хэлсэндээ байгаад энэ Үндсэн хуулийн

өөрчлөлтийг ажил хэрэг болгоод явуулах нь зөв юм биш үү гэсэн . . . /хугацаа дуусав/.

С.Бямбацогт: Мөнхбат гишүүнд минут сунгая.

Ж.Мөнхбат: Одоо үүнийг хүч түрээд цаашаа явах юм бол их зовлонтой асуудал үүснэ шүү, бодитойгоор. Тэгээд нийгмийн сэтгэл зүй, улс төрийн намууд, иргэний нийгмийн байгууллагуудын хандлага, ингээд олон, олон зүйл, тэгээд ялангуяа сонгууль дөхчихсөн ийм үе байна. Сонгууль дөхөхөөр нийгмийн массын сэтгэл зүй улам л улс төржингүй болдог ийм ийм нөхцөл байдлуудыг ойлгоод, дүгнээд явах нь яасан юм бэ? Бүлэг дээр ярилцсан асуудлаа би бүлгийн гишүүний хувьд хүндэтгэж үзэж байгаа. Гэхдээ хувь гишүүний хувьд үүнээс өөр гарц байхгүй юм байна гэсэн ийм итгэл үнэмшилтэй байгаа юм. Тэгээд саяны 4-5 асуултад хариулт авъя гэж бодож байна.

С.Бямбацогт: Лүндээжанцан гишүүн эхлээд хариулъя, дараа нь Энхболд дарга хариулъя.

Д.Лүндээжанцан: Санал асуулгын тухай хуулийн 7.1-д, санал асуулга явуулах өдрийг уг шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш 21-45 хоногийн дотор явуулахаар Улсын Их Хурал товлон зарлана гэж байгаа юм. Тэгэхээр санал асуулга явуулахыг нь бол гарчихсан. Тов тогтоосон шийдвэр гарснаас хойш, хүчин төгөлдөр болсноос хойш 21-45 хоногийн дотор зохион байгуулна. Тэгэхээр дор хаяхад 21 хоногийн өмнө гарсан байна гэсэн үг, энэ тов нь. 21 хоногийн дотор гарахгүй бол хүмүүс мэдээлэлгүй байна гэсэн үг. Тэгээд бэлтгэл ажлаа хангаад 45 хоногийн дотор явуулна гэж. Ийм 21-45 хоног гэдэг. Тэгээд энэ заалтыг тайлбарлахад, ингээд дутуу уншихаар санал явуулах тухайн өдрийг уг шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш 21-45 хоногийн дотор явуулахаар Их Хурал зарлана гэхээр, яг одоо үүнийг бүтэн уншиж байж ойлгоно уу гэхээс биш, ингээд салгаж аваад уншихаар ойлгогдохгүй байгаа юм.

Тэгэхээр энэ бол Санал асуулга явуулах Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн эхийг батлах тухай тогтоол гарлаа. Дараа нь залгаад тов тогтоож, ард түмний юуг хангах билүү, тийм нэртэй тогтоол, комисс гарчихсан ажиллаж байна шүү дээ, гарах гээд. Гэтэл дунд нь ингээд хориг орж ирээд шинэ нөхцөл байдал үүсэж байгаа юм. Тэгэхээр бид бүхэн бол хэдний өдрөөр зарлах вэ, тэр зарласнаасаа хойш 21-45 хоногийн дотор явуулна гэдэг энэ хуулийн лавлагааг бидэнд Тамгын газраас гаргаж өгсөн байгаа, тийм байхаа, тийм. Гаргаж өгсөн. Энэ дээр ийм зүйлийг хэлэх юм.

Үндсэн хуулийн, хуулийн хэлбэртэй болно гээд явуулахыг эхлээд би ярилаа шүү дээ. Ер нь нэг хуультай байхгүй бол болохгүй юм байна гэдэг ойлголтод хүрээд бид нар тэр хуулийг хийсэн. Манай Чимид багш голлоод. Ингээд маш олон цоож хийж өгсөн гэдэг тийм шүүмжлэл байнга л байгаа. Өргөн баригдаад ирэхийн үед энэ хуулиараа явна гэхээр Үндсэн хуулийн яг энэ заалттай, энэ заалт нь зөрчилдөөд байгаа учраас сүүлд нь хэдийгээр Үндсэн хуулийн цэц бага суудлын хуралдаанд хийгээд зөрчөөгүй байна гэсэн, цаад уг нь зөрчилтэй байгаа учраас энэ бол эрсдэлтэй юмаа. Ердийн хуулиар Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна гэдэг бол. Хэдийгээр Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын хуульд ингэж заасан ч байлаа гэсэн. Үндсэн хуульд өөрт нь Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт нь Үндсэн хуулийн адил хүчинтэй байна. Үндсэн хууль, хууль хоёр өөрөө зөрчилтэй гээд ингээд заачихсан учраас бид хуучин баримталж байсан үзэл баримтлалаа энэ талаарх ойлголтоо өөрчлөхөөс аргагүй байдалд ороод, олон талаас нь ярьж, ярьж одоо энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт гэдгээр явж байгаа юм.

Дураараа өөрчлөлт оруулах асуудал хориотой учраас Зөвлөлдөх санал асуулгын хуульд заавал зөвлөлдөх санал асуулга явж байж сэдвийг гаргаж байж, сая өөрчлөлт оруулна гээд ингээд бүхий л процессыг маш олон шат дамжлагатай, шавар дундуур туучиж байж өдий зэрэгтэй явж ирсэн юм. Дээр нь Үндсэн хуулийн цэцэд бид нар өгсөн, тийм байхаа, яг одоо үүнийг ингээд өргөн барилаа, тэгээд Үндсэн хуулийн цэцээс санал аваагүй гээд бас . . ./хугацаа дуусав/.

С.Бямбацогт: Лүндээжанцан гишүүний минутыг сунгая, хариулт.

Д.Лүндээжанцан: Үндсэн хуулийн цэцээс ирсэн бичиг дотор үүнийгээ хууль гэж нэрлэ гэсэн ийм санал ирээгүй. Ер нь Үндсэн хуулийн үндсэн бүтэц, суурь үзэл баримтлалд нийцүүлж Үндсэн хуулийнхаа нэмэлт, өөрчлөлтийг явуул гэдэг ийм л бичиг ирүүлсэн. Тэгэхээр би Цэцийн хувьд үүнийг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт гэдгээр нь ойлгож байгаа юм байна, одоогийн бүрэлдэхүүн. Тэр Цэцийн 9 гишүүн нийлж хуралдаад, тэгээд саналаа явуулдаг. Би ингэж ойлгож байгаа.

С.Бямбацогт: Энхболд дарга хариулъя.

3.Энхболд: Мөнхбат гишүүний асуултад хариулъя. Цэц дээр очих уу, очих магадлал бараг 100 хувь байгаа. Очсон хойноо яаж шийдэгдэх вэ гэхээр, энэ 2013 оны 10 сарын 11-ний өдрийн Цэцийн гишүүний 87 дугаар тогтоол, 2013 оны 11 сарын 20-ны 24 дүгээр магадлал, үүний дагуу шийдэгдэнэ. Хүн нь солигдсон ч гэсэн энэ байгууллагын түүх байж байгаа шүү дээ. Энэ хуулийг зөв

гэсэн, энэ хуулийн дагуу явуул гэсэн байр суурь нь. Тэгээд одоо хүнтэй нь тохироод явчихдаг юм бол байхгүй байхаа Лүндээжанцан гишүүн ээ. Энэ чинь байгууллага учраас урьд өмнө гаргасан шийдвэрээ хамгаалах байлгүй дээ гэж бодож байгаа юм.

Хэсэгчлэн хүлээж авч болно. Хоригийг ямар хэмжээнд хүлээж авах вэ гэдэг Улсын Их Хурлын өөрийнх нь бүрэн эрхийн асуудал. Хууль гэдэг процедуртай холбоотой нэг хэсэг асуудал хөндсөн, нөгөө дэх нь 25.1.16-г үндэслээгүй, ард нийтийн санал асуулга явуулдаг Үндсэн хуулийнхаа заалтыг хаясан байна гэдэг ийм 2 үндсэн хориг байгаа. Тэгээд аль нэгийг нь аваад найруулаад явах бүрэн бололцоотой.

С.Бямбацогт: Би бас нэмээд хариулъя гэж бодож байна. Хэсэгчлэн авах бололцоотой гэж байна. Ер нь бол хэсэгчлэн аваад, үндсэндээ 5 үндэслэлээр хориг тавьсан байгаа. Тэр 5 үндэслэлээс одоо энэ үндэслэлээр нь хоригийг хүлээж авах бололцоотой, бусад үндэслэлээр нь авах боломжгүй гэж хэсэгчилж авах бололцоотой гэдэг байдлаар сая хариулт өгсөн.

Тэгэхээр Улсын Их Хурлын 62 гишүүн өргөн барьсан. Өргөн барихдаа мэдээж олон талаас нь судалсан, ярьсан. Урьд өмнө өргөн барьж байсан Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг өргөн барьж байсан жишгүүд байж байгаа. Түрүүн Лүндээжанцан гишүүн хэлсэн 1999 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт өргөн баригдаад, батлагдсан. 2000 онд нэмэлт, өөрчлөлт өргөн баригдаад, батлагдсан. 2010 онд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хууль батлагдсан. Түүнээс хойш 2015 оны 11 сард Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Энхболд Улсын Их Хурлын дарга байхдаа, Монгол Улсын Ерөнхийлөгч Баттулга Улсын Их Хурлын гишүүн байхдаа, одоо Ардчилсан намын зөвлөлийн дарга Эрдэнэбат Улсын Их Хурлын гишүүн байхдаа 47 гишүүн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг өргөн барьсан. Ингэхдээ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт гэж Үндсэн хуулийн Жаран наймдугаар зүйлд заасны дагуу өргөн барьсан болохоос биш Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуульд заасан Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд хууль хэлбэртэй гэж өргөн бариагүй. Ийм жишгүүдийг бид нар дагаж, яг энэ жишгийн дагуу өргөн барьсан.

Ингэж өргөн барихдаа бас хууль хэлбэртэй байх асуудал, хууль хэлбэртэй байхын тулд Хууль тогтоомжийн тухай хууль, бусад хуульд заасны дагуу хууль маань өөрийн танилцуулгатай, үзэл баримтлалтай, тооцоо судалгаатай, хуулийн төслийн зүйл, заалттай байх ёстой. Энэ шаардлага бүрэн хангагдсан, журмын тухай хуульд заасан. Ийм байдлаар өргөн баригдсан гэдгийг нэмээд хэлчихье. Тийм болохоор Ерөнхийлөгчийн тавьж байгаа 5 үндэслэлийн 4 үндэслэл нь энэ хууль хэлбэртэй байх шаардлага

хангаагүй байна гэж авах хууль зүйн бүрэн үндэслэл байхгүй байгаа юм. Тийм болохоор үүнийг гишүүд маань энэ талаас нь ойлгож хараасай гэж хүсэж байгаа юм.

Мөн 2019 оны 7 сарын 16-нд Монгол Улсын Ерөнхийлөгч Үндсэн хуульд өөрчлөлт оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл саналыг өргөн барьсан. Энэ өргөн барьсан санал нь ч гэсэн, төсөл нь ч гэсэн бас Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл байсан, нэмэлт, өөрчлөлт нэртэй байсан. Ерөнхийлөгч өөрөө бас өргөн барьсан, 2019 оны 7 сарын 16-нд. Ингээд үзэхээр энэ үндсэндээ бүгдээрээ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл гэдгийг бүгд 5-6 удаа хэлэлцэх үедээ хүлээн зөвшөөрч явчхаад, өнөөдөр гэнэтхэн энэ биш байна аа гэж хэлэх нь хууль зүйн хувьд учир дутагдалтай юм шүү гэдгийг хэлье.

Тэр хоёр дахь хэлэлцүүлгийн үед бас асуудлууд яригдаж байгаа. Мөнхбат гишүүн асууж байна. Хэрвээ ингээд хоригийг хүлээж аваад, дахиад гурав дахь хэлэлцүүлэг дээрээ ч юм уу, эсхүл хоёр дахь хэлэлцүүлэг дээрээ задлах бололцоо, боломж бий юу гэж. Энэ бол бололцоо, боломж бас байхгүй ээ. Энэ дээр үндсэндээ хоёр дахь хэлэлцүүлгийн явцад Ардчилсан намын зөвлөлөөс байнга удаа дараа тавьж байгаа санал бол Ерөнхийлөгчийг парламентаас сонгодог болъё, үүнийг оруулъя гэдэг тийм саналыг байнга ярьдаг. Дээрээс нь холимог тогтолцоог байнга ярьдаг. Гэтэл үүнийг манай бүлгийн гишүүд яаж хүлээж авах билээ. Ерөнхийлөгчийн Тамгын газар, Ерөнхийлөгчийн зүгээс Ерөнхийлөгчийг парламентаас сонгодог бол буруу, үүнийг бид нар дэмжихгүй шүү гэж ярьдаг.

Эргээд Монгол Ардын намын бүлгийн гишүүд холимог тогтолцоо, гишүүдийн тоо нэмэх асуудлыг бид нар дэмжих ямар ч боломжгүй санал шүү гэж ярьдаг. Ингээд үндсэндээ тал, талдаа ийм зөрчилдөөнтэй үед бид нар арай гэж 57 гишүүний босго давсан хуулиа буцаагаад задлах бололцоо боломж тун бага байх. Одоо ингээд задалчих юм бол буцаагаад боогоод Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл маань батлагдах нь нэлээн төвөгтэй байдалд орох байхаа. Тийм болохоор үүнийг аль, аль талдаа гишүүд, хориг тавьж байгаа эрх бүхий субъект тал, талдаа бодож үзээсэй гэдгийг хэлье.

С.Бямбацогт: Мөнхбат гишүүн тодруулъя.

Ж.Мөнхбат: Энэ Үндсэн хуулийн зөрчсөн, зөрчөөгүй гэдэг маргаан тэгээд цаашаа хөвөрч өгөх нь л дээ. Хоригийг хүлээж авсан, хүлээж аваагүй гэдгээс шалтгаалаад л, Цэц руу очих магадлал өндөртэй байгаа юм байна. Цэц дээр шийдвэр гаргахад урьд өмнөх жишиг болсон процедурын дагуу ингээд явах, бас ийм магадлал байгаа юм байна. 1999 оны дордуулсан 7 өөрчлөлт

гэдгийг өөрчлөхөд Үндсэн хууль дээр өөрчилсний дараа Ерөнхийлөгч гарын үсэг зурж, баталгаажуулж байгаа тийм ээ? Одоо ингээд хоригийг хүлээж авахгүй, ингээд цаашаа явлаа гэж бодъё л доо. Ингээд явахад хэрвээ одоо ингээд эцсийн хэлэлцүүлэг хийгээд батлагдлаа. Энэ дээр Ерөнхийлөгч баталгаажуулах уу? Гарын үсэг зурах уу? Түүнийг Энхболд даргаас асууя.

С.Бямбацогт: Энхболд дарга хариулъя. Журмын тухай хуульд бас тодорхой заачихсан байгаа тийм ээ.

З.Энхболд: Журмын тухай хуульд заагдсан үүргээ Ерөнхийлөгч биелүүлнэ, түүнийг биелүүлэхгүй байх үндэслэл байхгүй. Ердийн хуулиас онцгойлж үзсэн, өөрөөр зохицуулсан байна билээ. Асуудал нь түүндээ биш л дээ. Ерөнхийлөгч Үндсэн хуулийн өөрчлөлтийг эсэргүүцээд, эсхүл ард нийтийн санал асуулгыг эсэргүүцээд байгаа зүйл огт байхгүй. Олон жил яриад, тохирсон энэ текст нь Үндсэн хууль болоод, маргаангүй батлагдаад яваасай гэж хүсэж байгаа учраас энэ хоригийг тавьж байгаа юм. Алдаа мадаггүй гаргаасай. Дээр нь ард түмнээсээ асууж байгаа бол дэмжиж байна, дэмжихгүй байна гэдэг хоёрхон үгний нэгийг сонгуулах гэж 30 тэрбум төгрөг зарцуулах бол буруу байна гэж байгаа юм. Сонгуулийн үеэр давхар асуугаад мөнгө, төгрөггүйгээр шийддэг арга бас байна, хэрвээ асууж байгаа бол. Тэгэхгүй гэж . . ./хугацаа дуусав/.

С.Бямбацогт: Энхболд даргын минутыг сунгая.

З.Энхболд: мөнгө төгрөг нь байхгүй юм чинь сонгуультай хавсаргаж явуулж, асууж болно. Эсхүл гуравдугаар хэлэлцүүлгээрээ Улсын Их Хурал өөрөө мэдээд дуусгаад, батлаад явж болно. Аль ч тохиолдолд Үндсэн хуульд оруулсан өөрчлөлт баталгаатай. Тэгэхдээ Цэц дээр очоод бүдрэхгүй байхын тулд энэ хуулиа дагаж хийсэн өөрчлөлт шиг хуулийн дагуу хийсэн өөрчлөлт байхгүй бол болохгүй байна аа. Ард нийтийн санал асуулга гэдэг бол Үндсэн хуульд яаж өөрчлөлт оруулах вэ гэдэг зөвшилцлийн ардчиллын эхний үед байсан тэр хэсгийг хэлж байгаа юм. Түүнээс Улсын Их Хурал Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулчихсан, одоо үүнийг баталгаажуул гэдэг тулгалт бол ард нийтийн санал асуулга бишээ. Үндсэн хуулийн Хорин тавын 1.16-д заасан АНСА гэдэг үйл явц бишээ. Ратификаци буюу их өөр зүйлийн тухай ярьж байгаа.

С.Бямбацогт: Эрдэнэбат гишүүн асуултаа асууя.

Д.Эрдэнэбат: Энэ ард түмнээс сонгогдсон Ерөнхийлөгчийн хориг гэдэг бол зүгээр нэг улс төрийн хүчний нэг ийм өөрсдийнх нь сэтгэлийн хөөрлөөр, өөрсдийнхөө зүйлийг хүчээр баталгаажуулахын тулд хийдэг үйлдэл биш л дээ.

Би энэ бүхэлд нь тавьсан хоригийг Улсын Их Хурал энэ эх баригчид нэг алдаагаа засах боломж гарч байна гэж бид ингэж хараад байгаа юм. Асуудлыг энэ талаас нь хараасай гэж. Тийм учраас Ардчилсан нам бол энэ санал асуулгын талаар болон Ерөнхийлөгчийн хоригийн талаар зөвшилцөх саналыг Их Хурлын даргад тавьсан л даа. Яах вэ захирамж гаргасан. Тэгээд нэг удаа хуралдсан. Цаашаа ингээд хуралдаагүй, шийдэл гараагүй байхад өнөөдөр Ардын намын бүлэг хоригийг хүлээж авахгүй гэдэг шийдвэр гаргаж байгаа нь бол би туйлын яарсан шийдвэр болов уу л гэж ингэж харж байгаа юм. Алдаа бол гарсан шүү дээ. Тэгээд Энхболд дарга, Лүндээ дарга 2 ингээд мэтгэлцээд л байна. Энэ журмын тухай хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулах. Хэлбэр нь зөвхөн хууль байна гэсэн заалт байгаа. Хажуугаар нь нэмэлт, өөрчлөлт оруулах хууль санаачлах ёстой гэсэн заалт байгаа байхгүй юу. Тэгээд хууль санаачлах талаар нь явахгүй бол энэ чинь Үндсэн хуулийн зөрчил болоод цэц дээр унах гээд байна гээд энэ Энхболд дарга тайлбарлаад байх шиг байгаа юм.

Бид процессын алдаа гаргаснаа бол хүлээн зөвшөөрч, цаашаа бид нийт зөвшилцөл ойлголтоор явахгүй бол энэ өөрөө мухардалд орно. Би мухардалд орно гэдгийг бүр мэдрээд байгаа юм.

Яах вэ, та нар Ардчилсан намыг, Ерөнхийлөгчийн энэ дээр авахгүй бид нар олуулаа байгаа юм чинь шийдээд явчихна. Эцсийн шийд яаж гарахыг хэн ч таашгүй нөхцөл байдалд энэ хууль өнөөдөр орчихсон. Энийг бүгдээрээ ухаарах хэрэгтэй.

Ардчилсан нам яагаад Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хоёрдугаар хэлэлцүүлгээс гарсан юм бэ гэхээр 62 гишүүний өргөн барьсан хууль Лүндээжанцан гишүүний хэлснээр Ардчилсан намын хүртэл оролцоо байсан гэдэгтэй би санал нэгддэг. Тэгэхдээ сонгодог парламентын амин сүнс хэдэн заалтуудыг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хоёрдугаар хэлэлцүүлгээс аваад хаячихсан байхгүй юу. Тэр тогтолцооны асуудлыг, Ерөнхий сайдын бүрэн эрхийн асуудлыг, сайд нараа томилох, тийм ээ? Тэр давхар дээл энэ тэрийг чинь аваад хаячихсан байхгүй юу даа. Тэгээд энэ хууль чинь зэрэмдэг болчихсон. Өөрөөр хэлбэл энэ нэмэлт, өөрчлөлт чинь өөрөө ардчилсан сонгодог парламентын засаглалын тогтолцоог баталгаажуулах эрх зүйн үндсийг тавьж чадаагүй байхгүй юу. Тэрний оронд баахан популистын заалтууд орсон учраас ардчилсан нам энэ хэлэлцүүлгээс гарлаа л гэсэн шүү дээ. Гарах нь зөв байсан гэж би одоо харж байгаа.

Одоо Ерөнхийлөгчийн хориг бид нар дээр ямар боломжийг олгож байна вэ гэхээр энэ бүх алдаануудыг засаад Үндсэн хуулийнхаа нэмэлт, өөрчлөлтийн үнэхээр зарчмын тэр гол саналууд дээр, амин сүнсийг нь тэр саналууд дээр санал нэгдэх боломжийг л олгож байгаа шүү дээ. Энэ хууль батлагдаагүй хууль шүү дээ. Хоёр дахь хэлэлцүүлэгт явж байгаа хууль. Ерөнхийлөгчийн хориг бүхэлд нь тавина гэдэг бол хоёрдугаар хэлэлцүүлэг задлахыг зөвшөөрч байгаа асуудал байхгүй юу. Батлагдсан хуулийг яривал нэг өөр. Одоо гуравдугаар хэлэлцүүлэг рүү явах гэж байгаа хууль шүү дээ, энэ чинь. Одоо бүгдээрээ гүрийгээд, гэдийгээд хэвтчихсэн өөр өөрийнхөө хувилбараар тайлбарлаад хуулиа. Болохгүй ээ энэ чинь. Хоёрдугаар хэлэлцүүлгийг задалдаггүй байхгүй юу. Тийм заалт ямар ч хуульд байхгүй. Ардчилсан нам нэг

зүйлийг санал болгосон Их Хурлын даргатай санал болгосныг би зөв гэж хараад байгаа. Энэ боломжийг хэдүүлээ зөв ашиглая. Парламентын хариуцлагатай улс төрийн хүчнүүдийн хувьд.

Ерөнхийлөгчтэйгөө зөвшилцөж байгаад энэ хоригийг хүлээж аваад, энэ сонгодог парламентын чиглэл рүү явж байгаа хэдэн хасагдсан энэ зэрэмдэг болгосон заалтуудыг оруулаад цаашид нь ард нийтийн санал асуулгаар явах уу, гуравдугаар хэлэлцүүлэг рүү явах уу гэдийг эрүүл ухаанаар шийдье.

Ард нийтийн санал асуулгыг бол асар өндөр өртөгтэй гарч байгаа гэдэгтэй би санал нэг байна. Үгүй энэ чинь одоо.

С.Бямбацогт: Эрдэнэбат гишүүнийг 1 минут сунгая.

Д.Эрдэнэбат: Үгүй ээ, энэ чинь одоо юу яаж байна шүү дээ. Хоёр удаагийн Улсын Их Хурлын сонгуулийн дайтай зардал гарах гэж байна шүү дээ. Байж болохгүй зардал шүү дээ. Энийгээ хэдүүлээ эрүүлээр ярья гээд. Би тэгээд Энхболд даргаас бас нэг зүйл тодруулж асуумаар байна. Энэ 73 дугаар тогтоолыг тэр түрүүн ярилаа шүү дээ. Тэр хугацаа, төсөв 2-ыг тогтоогоогүйгээр гаргасан нь хуулийн зөрчил мөн үү? Би бол мөн гэж харж байгаа. Их Хурлын дарга яаран энийг баталсныг би тэгээд чуулган дээр шүүмжилсэн шүү дээ.

Энэ тогтоолд чинь орох ёстой хоёр заалт орсонгүй. Нэг нь хугацаа, нөгөөдөх нь төсөв. Яагаад ингэж буруу инцидент үүсгэсэн юм бэ гэж. Тэгэхээр надад дээр энэ хариултыг өгөөч ээ гэж хүсэж байна баярлалаа.

С.Бямбацогт: Энхболд дарга хариулъя. Нэмээд би бас хариулчихъя.

З.Энхболд: Төрийн байгуулалтын байнгын хороогоор хэлэлцэж байгаад завсарлага аваад зогсчихсон байгаа тогтоол. Уг нь энэ тогтоолтой цуг гарах ёстой юм. Хугацаа болон хөрөнгийн шийдэж өгсөн. Тэгээд тэндээсээ эхлээд 21 хоног, 45 хоногоо тоолох ёстой. Одоо тэгэхээр энэ тогтоолоос эхэлж тоолох уу? Удаагүй гарах гэж байгаа тогтоолоос эхэлж тоолох уу гээд дахиад маргааны үндсийг тавьчихаад байгаа юм. Санал асуулга явахаар тогтсугай гэдэг өдрөөс эхэлж тоолмоор юм шиг байгаа юм бас. Тэгээд бодохоор одоо 12 сарын эхний 7 хоногоос хэтрүүлэхгүй байх болчих гээд байгаа юм, тэр тогтоолоороо. Хориг хүлээж авсан, аваагүйгээр Улсын Их Хурлын 73 дугаар тогтоол хүчинтэй болно гэх юм бол хүчинтэй болсон өдрөөс нь бас тоолох гээд байгаа юм. Тэгэхээр одоо маргааш чуулганаар авна. Эсвэл авахгүйгээр шийдчих юм бол 10 сарын 4-нөөс 45 хоног гэхээр чинь 12 сарын эхээр үү? 11 сарын 20 уу тийм ээ? Биш ээ, 11 сар чинь бүтэн орно шүү дээ. Тэгээд 15. Тийм, тийм. 11 сарын 20 юм байна. Тэгэхээр 11 сарын 20 гэдэг өдрөөр. Маргааш бас дахиад нөгөө зардал болон санал асуулга явах өдрөө гаргасан тогтоолоо гаргаад тэр нь дээр хориг тавихгүй 5 хоног гээд ингээд явахаар 12 сар луу орчих гээд байгаа юм. Тэгэхээр ингээд нэг юмнаасаа гараад нөгөө юм руугаа ингээд маргаантай юм яваад байвал цаашид нөгөө олзлогдоод хүчингүй болох магадлал улам өсөөд л байна гэсэн үг.

Хууль гэдгийг Лүндээ гишүүнийнхээр ингээд нэг их хөнгөхөн тайлбарлаад гарчих, мултрахад их хэцүү л юм байна лээ. 1991 онд нэг өөрчлөлт хийгээд

дордуулсан долоо гээд 10 жил үү? 20 жил үү? Тийм 20 жил. 20 жил явсан. Одоо дордуулсан далан өөрчлөлт гэдэг хочтой болоод ч явчих юм билүү. Яах вэ олонхоороо шийдэж болох л байх. 60-н хэдэн өөрчлөлт байна лээ л дээ. Тэгээд дордуулсан 70 өөрчлөлт гээд дахиад олон жил цоллуулах юм гарчихгүйн тулд л алдаагаа засчихаад явчихъя л гээд байгаа юм.

С.Бямбацогт: Хуулийн 2 заалт би нэмээд хариулчих уу? Тэгэхээр юу яаж байгаа юм. Ард нийтийн санал юу, Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах журмын тухай хуулиар бид нар 73 дугаар тогтоол нь 2 заалттай байгаа.

17.1 дээр бол Улсын Их Хурал төслийн 14 дүгээр зүйлд зааснаар хэлэлцээд тухайн нэмэлт өөрчлөлтийг ард нийтийн санал асуулгаар оруулах нь зүйтэй гэж үзвэл гэж Улсын Их Хурлын нийт гишүүний гуравны хоёроос доошгүйн саналаар тогтвол Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1.16 дахь заалт, жаран найм дугаар зүйлийн 2 дахь заасныг үндэслэн тус тус үндэслэн ард нийтийн санал асуулга явуулах тухай тогтоол гаргана гээд. Энэний дагуу бид нар 73 дугаар тогтоолын нэг дэх заалтаараа ард нийтийн санал асуулга явуулах тогтоолын нэг дэх заалт гарсан.

Журмын тухай хуулийн 17.3 дээр дахиад нэг заалт байж байгаа. Энэ дээр хоёр дахь хэлэлцүүлгээр зүйл, хэсэг, заалт бүрээр санал хурааж шийдвэрлэсэн төслийг ард нийтийн санал асуулгад оруулах эх болгон баталж уг эхээр ард нийтийн санал асуулга явуулах тухай Улсын Их Хурлын тогтоол гаргана. Яг энэ 17.3 дахь заалтын дагуу бид нар Үндсэн хуулийн ард нийтийн санал асуулгад оруулах эхийг баталсан. Одоо үүний дараа бид нар ард нийтийн санал асуулгыг хэзээ, хэрхэн яаж зохион байгуулах уу гэдэг тогтоолыг гаргах ёстой. Энэ тогтоол нь гараагүй байж байгаа. Энэ тогтоолыг гарсан өдрөөс хойш түрүүн Мөнхбат гишүүн асуусан. Ард нийтийн санал асуулгын тухай хуулийн 7.1-т заасны дагуу санал асуулга явуулах тухай шийдвэрт санал асуулга явуулах өдрийг уг шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш 21-ээс 45 хоногийн дотор явуулахаар Улсын Их Хурал товлон зарлана гэсэн байгаа. Тийм болохоор үндсэндээ бид нар хэзээ, хэрхэн яаж явуулах уу, тийм ээ. Ямар одоо хөрөнгө зардал гарах уу гэдэг тогтоолыг батална. Тэр өдрөөс хойш 21-ээс 45 хоног маань тоологдож эхэлнэ.

Одоо тэр Энхболд даргын хэлээд байгаа 30 тэрбум гээд яриад байгаа асуудал бол тодорхой тооцоо, судалгаа бол Сонгуулийн Ерөнхий хорооноос анх ирсэн. Сонгуулийн Ерөнхий хороо анх тооцоо, судалгаа ирүүлэхдээ дутуу ирүүлсэн байсан. Тийм учраас дахиж тэр хуульд заасны дагуу Сонгуулийн ерөнхий хороог тэр ард нийтийн санал асуулга явуулах тэр зардлынхаа тооцоог дахиж ирүүл гэсэн. Дахиж ирүүлсэн байгаа. Тэр нь дээр гарсан тоогоор бол тийм 30-аад тэрбум гарахаар зардал бол байхгүй байгаа юм байна лээ. Энийг одоо удахгүй Их Хурал хэлэлцэх байх гэдгийг нэмж хэлье.

Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хоригтой холбогдуулж санал хэлэх гишүүд нэрсээ өгье.

Мөнхбат гишүүнээр тасаллаа. Баасанхүү гишүүн саналаа хэлье.

О.Баасанхүү: Би бол хоригийг авъя л гэж үзэж байна л даа. Яагаад вэ

гэхээр 3 шалтгаан байна л даа.

Нэгдүгээрт, юу вэ гэх юм бол одоо ард нийтийн санал асуулга явуулж байгаа нь ач холбогдолгүй болчих гээд байна л даа. Яагаад ач холбогдолгүй гэж үзэж байгаа вэ гэхээр ард түмэн чинь өнөөдөр төслөө гар дээрээ аваагүй байна шүү дээ. Аваад уншаад, үзээд зөв байна, буруу байна. Энэ нь сайн заалт байна, энэ нь муу заалт байна гэж ойлгосоор байтал нөгөө нэг өвөл нь болно. Өвлийн идшээ гаргаад энэ тэрээ гээд сууж байх хооронд санал асуулга гээд гэрт нь нэг та дэмж, эсвэл эсэргүүц гэсэн дээрээс нь нөгөөдүүл нь юу вэ гэвэл нөгөө парламентыг тарааж байгаа асуудал юм болов уу, ард нийтийн санал асуулга юм болов уу гээд одоо бүр будилах хэмжээнд очиж байна шүү дээ. Хүн болгон мэдээлэлтэй гэж би бас үзэхгүй байгаа байхгүй юу. Тэгэхээр ингэж санал асуулга явуулж ингэж байхаар төлөөллийн ардчиллаараа баталчихаад тэгээд дараагийн одоо парламент нь ирээд муу бол дэмжээд, сайн бол эсэргүүцээд явах хэрэгтэй. Тэртэй тэргүй Ардын намд 2 үүрэг өгсөн юм. Нэг нь ард түмний амьдралаа сайжруул гэсэн чадахгүй юм байна. Өнөөдрөөс эхлээд тэр нүүрсэндээ угаартлаа гээд юм явлаа шүү дээ.

Хоёрдугаарт нь одоо юу вэ гэх юм бол. Ард түмэн Ардын намыг нөгөө Үндсэн хуулийг өөрчил гэсэн. Тэгэхээр тэрийгээ бол одоо шийдэхээс дээ гэж. Ингээд одоо тэд нар өөрсдөө шийдэх. Хоёрдугаарт нь хууль зүйн үүднээсээ энийг дэмжихээс өөр аргагүй болчихоод байгаа юм. Яагаад гэхээр, журмын тухай хууль гээд угаасаа л байдаг шүү дээ. Үндсэн хуулиа баталчихсан юм бол Үндсэн хуульдаа нийцүүлээд Үндсэн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль гэж явна биз дээ. Энэ чинь Үндсэн хуульд нийцүүлж хууль батлаач ээ гээд Ерөнхийлөгч хэллээ гэж би ойлгоод байна шүү дээ. Буруу ойлгоод байна уу? Тэр утгаараа уг нь асуусан бол үнэн л гэх байх даа. Энэ утгаараа энэ чинь нөгөө бас Монгол төрийн тэргүүн, 2 сая иргэний дундаас өрсөлдөөд гараад ирсэн нь үнэн л юм чинь ард түмний төлөөлөл хориг тавьж байгаа гэж үзэх хэрэгтэй л дээ. Энд нам бол хамаагүй байх л даа. Тэр утгаараа зүгээр энийг дэмжсэн нь дээр, зөв юм уу л гэж би бодож байна, хоригийг.

С.Бямбацогт: Баярлалаа. Хаянхярваа гишүүн саналаа хэлье.

Д.Хаянхярваа: Хоригтой холбоотой асуудлыг зүгээр янз янзын байдлаар л ярьж байна л даа.

Зүгээр би энийг ингээд сонсоод суухад хуульч хүн биш ч гэсэн би сонсоод сууж байхад бол өөр өөр өнцгөөс тайлбарлаад байх юм. Би ойлгохдоо бол Ерөнхийлөгчийн хоригийг бид нар ерөөсөө хувь гишүүний гэдэг юм уу, одоо улс төрийн нөхцөл байдлыг гэдэг талаас ярихаасаа илүүтэйгээр яг хуулиа зөрчиж үү, үгүй юу. Үнэхээр тэр Үндсэн хуулийг зөрчиж үү, үгүй юу. Одоо Ерөнхийлөгчийн тавиад байгаа хориг тэр хууль зүйн үндэслэл нь одоо үндэстэй юм уу, үгүй юу. Бид нарын зүгээс одоо сэргүүлж тавиад байгаа, хууль зөрчөөгүй гэж байгаа нь хуулийн үндэслэлтэй юм уу, үгүй юм уу гэдгийгээ ярьж байж л хуулийн хүрээн дотор, хуулийн дагуу шийдэх ёстой гэж бодож байна. Түүнээс биш одоо улс төрийн нөхцөл байдал тэгээд дараа нь урьдчилан таамаглаад. Одоо энийг ингээд авчихвал ийм юм үүснэ, ингэхгүй бол тийм юм үүснэ. Тогтворгүй байдал бий болно гэх мэтчилнээр янз бүрийн байдлаар ингээд энд бол хоригийн тухай, хоригтой холбоотой асуудлыг бол

тайлбарлаад байх нь арай зүйд нийцэхгүй байх гэж би хувьдаа бодож байгаа юм.

Нэгэнт одоо Лүндээжанцан нарын 62 гишүүний өргөн барьсан хуулийн төслийг өргөн бариад явах явцад хоёрдугаар хэлэлцүүлгийн дундаас Ерөнхийлөгчийн өргөн барьсан хууль гэж орж ирээд санал болоод явсан. Тэр нь дээр бол би эргэлздэг. Өөрөөр хэлэх юм бол тэр бол Үндсэн хууль зөрчиж байна уу, үгүй юу гэдэг дээр. Манайхан бол тайлбар хийхдээ бол энэ хууль гэж өргөн бариад хоёрдугаар хэлэлцүүлгээс энийг санал гээд хэлэлцээд явчихаж болно гэж. Одоо бол ний нуугүй хэлэхэд бол Үндсэн хууль зөрчсөн, зөрчөөгүй цэцийн дүгнэлт гэдэг чинь яг нарийндаа ярих юм бол ёстой жинхэнэ улс төрийн үзэмжийн асуудал болж хувирчих гээд байна шүү дээ. Ингэж л цаашдаа явмааргүй байгаа юм.

Яг үнэндээ бол өнөөдөр хэрвээ бид нар энэ хоригийг одоо хүлээж авна гэвэл энэ хуулийг зөрчсөн хүндээ бид нар хариуцлага тооцох ёстой. Одоо яг энийг хүлээж авсан. Тэгээд одоо хууль зөрчиж энэ хэлэлцүүлгийг хийсэн. Энэ бүх асуудлуудтайгаа бол эргэж л ярих ёстой гэж би бол ингэж л бодож байгаа. Тэгэхгүйгээр одоо зүгээр ингээд явж байгаад, найран дундаа явж байгаад миний ч тэр санал үлдсэн, тэрний ч тэр санал үлдсэн. Ер нь боломжоо хангачихъя, ийм болгочихъё гэдэг ийм өнгө аясаар яваад байвал энэ таарахгүй гэж бодож байгаа.

Би бол Лүндээжанцан даргын хэлээд байгаа тайлбартай бол санал нэгдэж байгаа. Өөрөөр хэлэх юм бол өргөн барьсан хуулиа өргөн барьсан хүн тэр хуулийн хүрээнд, хууль зүйн үндэслэлтэй тайлбараа хэлээд байна. Тийм учраас энэ бол одоо хууль зөрөөгүй байна гэж үзэж байгаа учраас хоригийг хүлээж авах боломжгүй гэж үзэж байна гэдэг энэ чиглэлд нь бол байгаа. Ер нь ингээд оруулж ирсэн материалуудад бид нар үзэхэд бол дандаа бид нар хүний өгөөш болох юм. Яг ний нуугүй хэлэхэд тэр 30 тэрбум гэдэг асуудал бол маш хуудамгай орж ирсэн. Зүгээр л гэв гэнэтхэн нэг өдөр 30 тэрбум гээд ороод ирчихсэн. Тооцоо үндэслэлээ сүүлд нь хасахад нь хүртэл би бүлэг дээр саналаа хэлж л байсан. Ямар ямар зардлуудыг нь хасах ёстой юм бэ, тэрийгээ олон түмэнд одоо хэлж хас. 30 тэрбум гэдэг зардлаас чинь одоо хасаад ороод ирье гэхэд 10 тэрбум болгоод ороод ирье л дээ. Тэгвэл 20 тэрбумыг яах гэж та нар илүү тавьж орж ирсэн юм бэ гэдэг асуудал гарвал, хөндөгдвөл бид нар юу гэж тайлбарлах вэ? Тэгэхээр чинь ямар нэгэн юманд бол заавал тооцоо, үндэслэл, судалгаа нь байх ёстой.

Хэрвээ одоо үнэхээр энэ санал асуулгыг явуулахад 30 тэрбум гарах юм уу, 10 тэрбум гарах юм уу, 5 тэрбум гарах юм уу гэдэг чинь заавал тооцоо, үндэслэл, судалгаатай орж ирж байж энэ Их Хурал дээр яригдаж байх ёстой. Тэгэхэд ерөөсөө бид нар бол асуудалд яаж хандаж байна гэхээр маш хуудамгай хандаж байгаагийн жишээ бол, наад захын жишээ бол энэ. Ерөөсөө зүгээр л тавьж орж ирээд нэг хурдхан шиг л, ерөөсөө 2 яс салахын түйс болж. Ийм байдлаар хандаж цаашдаа асуудалд болохгүй гэдэг ийм зүйлийг хэлмээр байна.

Ер нь бол бид нар одоо энийг хуульчид бас маргаашийн чуулган болтол нэлээн сайн нэг зөвлөлдөх хэрэгтэй. Зөвлөлдөх хэрэгтэй. Яах вэ, өнөөдөр энэ

дээр одоо шийдвэр яаж ч гардаг бай, шийдвэр гардаг байж. Үнэхээр одоо хуулийн ийм зөрчсөн юм байгаа юм уу, үгүй юм уу. Энийгээ ний нуугүй одоо ёстой Ерөнхийлөгчийн Тамгын газрын хуульчид, Ардчилсан намын зүгээс байж байгаа хуульчид, өөр одоо хаана хуульчид байна. Сууж байгаад ний нуугүй ярьж байгаад бас нэг ингээд зөвшилцөлд хүрээд одоо ийм байна. Энэ асуудлаа цааш нь явъя гэдэг юмаа яриад явах юм бол нэг өөр асуудал. Тэгэхгүйгээр тэрнээс зүгээр одоо ингээд мухар, сохор мэтгэлцээн маягаар яваад, тэгээд нэг хэсэг нь дэмжинэ, дэмжихгүй гэдэг ийм байдлаар хандаад байвал наадах чинь үнэхээр Үндсэн хуулийн асуудал учраас бид нар бас үнэндээ нухацтай хандах ёстой гэдэг ийм байр суурьтай байна. Тэгэхдээ одоо энэ удаад бол би хүлээж авахгүй гэдэг итгэл үнэмшил дээр кноп дарна гэдгээ хэлье.

С.Бямбацогт: Баярлалаа. Д.Эрдэнэбат гишүүн саналаа хэлье.

Д.Эрдэнэбат: Би түрүүн асуултын үеэр өөрийнхөө зарчмын байр суурийг бас ойлгомжтой илэрхийлэхийг хичээсэн. Ойлгосон байх гэж бодож байна.

Бүхэлд нь тавьсан хоригийг хүлээж авна. Яагаад гэвэл энэ Үндсэн хууль гэдэг эцэг хуулийг хамтран ойлголцох эцсийн цэг нь өөрөө энэ юм. Ерөнхийлөгчийн зүгээс ч тавьж байгаа. Ардын намынхан ч түрүүн Ерөнхийлөгчийн хоригоос өмнө бөөн л юм боллоо шүү дээ. Бараг нийгмийг донсолгосон, гайхшируулсан, хачин хачин юмнууд их болж өнгөрсөн. Энэ нь өөрөө Монголын Улс төр сайн зүйлийг хэзээ авч ирэхгүй зүйл гэдгийг хаана хаанаа ойлгох хэрэгтэй. Энэ хориг дээр хэрвээ бүхэлд нь тавигдсан бол энэ тогтоолд тавигдсан, тогтоол дээр заагдсан нэмэлт, өөрчлөлтийн эх болон энэ ард нийтийн санал асуулга хоёрыг бүхэлд нь хүчингүй болголоо гэж ингэж ойлгоод бүх зүйлийг дахин ярилцах боломжийг бол нээж өгөх хэрэгтэй гэж би энэ эрх баригчдад хэлмээр байна.

Үнэхээр энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн эцсийн дүндээ 2 дугаар хэлэлцүүлгийн дараа яг амин сүнс болох гол мөн чанаруудаа алдаад хамгийн зэрэмдэг хууль болж хувирсан шүү. Энийгээ бүгдээрээ ойлгох хэрэгтэй. Одоо ард нийтийн санал асуулгыг яг энүүгээр явуулна гэвэл энэ буруу гэж ардчилсан нам үзэж байгаа учраас ард нийтийн санал асуулга яг энэ асуулгуудаар явуулах асуудал бол буруу болчихлоо. Энэ Үндсэн хууль чинь эхний тавьсан тэр шаардлагад нийцэж чадсангүй. Бодитой өөрчлөлт болж чадсангүй гэж үзэж энийг илэрхийлж байгаа юм.

Энд хамгийн эцсийн вариант дээр Ерөнхийлөгчийн хоригийг орж ирэхэд энэ Ардчилсан нам улс төрийн хариуцлагатай хүчний хувьд Ардын намтай ярилцъя гэдэг зөвшилцлийг байгуулах алхмыг хийснийг би бас зөв гэж үзэж байгаа. Энэ бидний боломж юм. Гэхдээ Ардын намыг үнэхээр ардчилсан үзэл баримтлалтай бас энэ ардчилсан Үндсэн хуулийг хамгаалах эрмэлзэлтэй байгаа бол бидэнтэй хамт зөвшилцлийг хийж энэ зэрэмдэг болгосон хуулийнхаа жаахан ч гэсэн засварыг хийх байх гэсэн горьдлогыг тээж бид нар энд орсон шүү. Түүнээс эсэргүүцэхийн тулд энд ороогүй.

Энэ улс орон сонгодог парламенттай л байх ёстой. Монголын ард түмэн 30 жил энэ ардчилал, зах зээлээр явахдаа энэ сонгодог парламентын хүчинд

ийм нээлттэй болсон гэдэг ерөнхий давуу талаа бид хэзээ ч мартаж болохгүй. Энүүгээр өдөөсөн ямарваа нэгэн сөрөг улс төрийн нөхцөл байдал руу өөрсдийгөө түлхэн оруулж бас болохгүй. Энэ бол энэ парламентад сууж байгаа нийт гишүүдийн эрх ашиг биш гэдгийг бид хаана хаанаа ойлгох хэрэгтэй болов уу гэж би ингэж бодож байна.

Тийм учраас энэ дээр хэдүүлээ цаашдаа бас яриа өрнөх байхаа. Өрнөх байх. Ард нийтийн санал асуулгыг өнөөдөр тогтоогоод, өвөл санал хураалт явуулна гэж байхгүй. Үндсэн хуулийг сонгууль эхлэхээс өмнө хэлэлцэх хориотой, өөрөө хуулиараа. Тэгэхээр өнөөдөр энд зөрчсөн тогтоолын дагуу дараа нь бид нар тогтоол гаргаад, жишээлбэл ээлжит сонгуультай ард нийтийн санал асуулгыг Үндсэн хуулиар явуулна гэдэг ийм хачин юм ярьдгаа одоо болих хэрэгтэй.

Ард нийтийн санал асуулга явуулъя гэвэл үнэхээр үндэсний зөвшилцөлд хүрч байж гуравдугаар хэлэлцүүлэг рүү орох боломж нь өөрөө энэ Ерөнхийлөгчийн тавьсан хориг гэдгийг бид хаана хаанаа ойлгож хэлэлцэх ёстой гэсэн байр суурь дээр байгаа. Тийм учраас Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж аваад цаашдаа энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг яг зөв голдирол руу нь явуулахын төлөө ажиллахыг хичээгээсэй гэж би та бүхнээс хүсэх байх.

С.Бямбацогт: Баярлалаа. Одоо Нямаагийн Энхболд гишүүн саналаа хэлнэ.

Н.Энхболд: Энэ хориг бүхэлдээ тавьчихсандаа бас их учир дагуулаад байна. Би бол тэгж ойлгож байна. Бүхэлд нь тавилаа гэхээр санал асуулга явуулах тухай хэсэг нь ч зогсож байгаа. Тэрүүгээр чинь бид нар хэлэлцүүлэх текстийнхээ эхийг бас баталчихсан. Тэр нь ч хүчингүй болчих юм. Ингээд хэлэлцэх юм байхгүй болж байгаа байхгүй юу. Хэлэлцэх юм байхгүй болохоор Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн асуудал зогсчих юм. Би л надад тэгж харагдаж байгаа юм. Бүхэлд нь тавьчихсан болохоор. Сая Энхболд дарга хэлж байна л даа. Хэсэгчилж хүлээж аваад болно энэ тэр гээд. Аягүй бол бид нар хэсэгчлээд хүлээн авчихдаг сүүлд нөгөөдхөөр нь бас та нар бүхэлд нь тавьсан байхад хагсыг нь аваад бас л худлаа одоо Үндсэн хууль зөрчсөн юм хийлээ гээд дахиад нэг ийм маргаан болох вий гэж бодоод байгаа юм. Миний ойлголт бол бүхэлд нь тавьчихсан болохоор бид нарын энэ бол 6 сарын ажил биш шүү дээ. Сүүлийн 10 жилийн ярьж ирсэн ажил бүхэлдээ зогсож байгаа байхгүй юу.

Ер нь манай мөрийн хөтөлбөртөө тусгаад Үндсэн хуульдаа нэмэлт оруулна гэсэн нэмэлт, өөрчлөлт хийнэ, сайн тал руу нь хандуулна, парламентын засаглалаа бэхжүүлнэ, ард түмнээсээ асууна гэсэн бидний зорилго бас зогсож байгаа юм. Ингээд нэг мухардалд оруулчхаж байгаа юм. Намайг жишээ нь хувь хүний хувьд. Тийм учраас би энийгээ явуулах тал дээр нь л байгаа. Хэдийгээр энэ дотор нь олон сайн юм байсан ч гэсэн хасагдсан ч гэсэн үлдэж байгаа юм нь дотор нь бол дандаа би бол урагшаа ахисан зүйлүүд л байгаа гэж харж байгаа. Нарийн үзвэл бас энэ чинь ахиулсан зүйлүүд бий шүү дээ. Гар бие оролцсоны хувьд тэгж бодож байна. Хоёрдугаарт би саяхан, өнгөрсөн 7 хоногт аймаг дээрээ очиж тойрог дээрээ нэлээн том арга хэмжээнд оролцсон. Яг энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг гүнзгий судлаад уншсан,

сонирхсон, судалсан хүмүүс бол ярьж байна лээ. Анхнаасаа орж байсан төсөл чинь их гайгүй гайгүй юмнууд байсан юмаа. Одоо тэгээд яах вэ нэгэнт ингээд зөвшилцөл, тал талын сонирхол орсоор байгаад нэг ийм хэмжээнд хүрчихлээ. Гэхдээ л та нар энийгээ баталсан нь зөв шүү гэсэн ийм байр суурьтай юм надад нэлээн олон хүн хэлсэн. Уншсан, судалсан улсууд дотроос нь ярьж байна шүү дээ. Тэгэхээр энийгээ явуулмаар байгаа юм. Одоо чухам гуравдугаар хэлэлцүүлгээр байна уу. Эсвэл энэ хоригийг хүлээж авахгүй гэж бодоход цааш нь дахиад үргэлжлүүлэх ямар гарц боломж байна гэдгийг би хайх хэрэгтэй гэдэг дээр санал нэг байна.

Энэ дотор нь бага ч гэсэн би түрүүн Тамгын газрын даргын хэлснээс бас нэг юм ойлголоо. Энийг бол гол нь агуулга талаас нь бид нар болохгүй, бүтэхгүй байгаад байгаа юм гээд байгаа юм биш ээ. Гаргачих нь зүйтэй гэсэн байр суурь Ерөнхийлөгчтэй байгаа. Ерөнхийлөгч. Ганцхан хууль зөрчиж үүнийгээ сүүлд нь Үндэсний цэцээр орох легитим чанаргүй болох ийм юм руу орох вий дээ л гэж болгоомжилж байна гэсэн, ийм үүднээс тавьсан хориг гэж ойлголоо.

Тэгэхдээ бүхэлд нь тавьчихсан болохоор одоо энийг чинь нөгөө баталсан эхээ бүхэлд нь хүчингүй болголтой биш дээ. Ямар хориг хүлээж авч байна гэж очоод дахиад одоо нөгөөдхөө бүгдийн эргээд тэр чигээр нь дахиад баталъя гээд явж байлтай биш. Надад бол хуулийн тийм гарц нь харагдахгүй байна. Дээр нь манай бүлэг өнөөдөр яриад шийдчихсэн. Байр сууриа илэрхийлсэн. Тэгэхээр миний байр суурь бол энийг авахгүй байгаад тэгээд харин цаашаа ямар бололцоо байна гэдгийн хуулийн хүрээнд хайх нь зүйтэй болов уу гэсэн ийм байр суурьтай байна. Бүхэлд нь тавьчхаагүй энэ хэсэг нь энэнээсээ боллоо, энэ энэ хэсэг нь боллоо гэсэн саяын жишээ нь Тамгын газрын даргын хэлсэн шиг бидэнд ойлгогдсоноор агуулга тал дээр нь юм байхгүй юм байна гэж ойлгогдохоор тийм хориг байсан бол арай илүү амархан шийдэгдэх байсан болов уу гэж бодож байна.

Тэгээд энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах үйл явцтай холбогдоод надад нэг ийм зүйл бодогдоод байх боллоо, сүүлийн үед.

Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага гээд манай Үндсэн хуульд заачихсан. Тэгээд одоо энэ төрийн эрх барих дээд байгууллага мөн байна уу, биш байна уу гэдэг асуудал тавигдах боллоо. Надад бодогдох боллоо. Төрийн эрх барих энэ ажлаа хийж чадаж байна уу, үгүй юу гэж бодогдох боллоо.

Үндсэн хуулийг бол нийгмийн гэрээ гэдэг л дээ. Тэгээд энэ нийгмийн гэрээг Монголын ард түмэн өнөөдрөөс 27 жилийн өмнө байгуулсан. Энэ гэрээг байгуулахдаа ямар нийгэм, ямар ард түмэн энийг баталсан, энийг байгуулсан бэ гэхээр 70 жил нэг намын тогтолцоо дор, захиргаадалтын тогтолцоо дор 3 үеэ өнгөрөөсөн хүний эрх, эрх чөлөө жинхэнэ одоо улс орны тусгаар биеэ даасан байдал гэж юмны давуу сайн талыг бүрэн дүрэн эдэлж чадаагүй тийм нийгэм, тэр саяны миний хэлсэн юмнуудыг хүсэж, мөрөөдөж байгуулсан ийм нийгмийн гэрээ байхгүй юу. Ийм Үндсэн хууль. Бид ардчиллыг сонгоно. Төлөөллийн ардчиллыг сонгоно.

С.Бямбацогт: Цаг дууссан. Нэг минут.

Н.Энхболд: Ийм юмаар бид нар ийм түүхтэй нийгэм, энэ Үндсэн хуулийг чинь байгуулсан юм. Тэгэхээр энэнээс буцах зам бол үнэхээр байхгүй. Харамсалтайн энэ хооронд улс төржүүлсээр байгаад, өнөөдөр өөрсдөө улс төржүүлсээр байгаад Их Хурлынхаа нэрийг ингээд доош нь хийчихсэн. Тэрнээсээ болоод бид нар нөгөө төлөөллийн ардчилал олонх энэ асуудлаа шийддэг, цөөнхөө хүндэтгэдэг энэ юмнаасаа больж эхэлж байна. Цөөнх нь үгүй гээд суучихвал энэ нь зогсчихдог ийм нийгэм, ийм замбараагүй байдал руу явж байна. Тэгэхээр асуудал юунд байна вэ гэхээр ерөөсөө энэ Улсын Их Хурал төрийн эрх барих дээд байгууллага гэдэг юм маань харин сүүлдээ гай болж байгаа юм биш байгаа даа. Чадахгүй байна гэдэг нь харагдаад байна шүү дээ. Энэ чадахгүй юм руу нийгмээрээ бид нар хориод сүүлийн 10-н хэдэн жил зүтгүүлчихлээ шүү дээ. Муулсаар байгаад. Солих бол сонгуулиараа л сольдог байх хэрэгтэй. Шийдвэр гаргадаг бол олонх нь шийдвэрээ гаргадаг байх хэрэгтэй. Цөөнхөө сонсдог байх хэрэгтэй. Ардчилсан намын оруулсан саналаас, Ерөнхийлөгчийн оруулсан саналаас бид нар олонх бололцоотой гэж үзсэн.

С.Бямбацогт: Энхболд даргад баярлалаа. Мөнхбат гишүүн саналаа хэлье.

Ж.Мөнхбат: Энэ Үндсэн хуулийг өөрчилнө гэдэг асуудлыг бол би Улсын Их Хурлын гишүүн болсон цагаасаа, анхнаас нь дэмжиж ирсэн хүн. 2016 онд бас Засгийн газрын Хэрэг эрхлэх газар байхдаа манай Эрдэнэбат Ерөнхий сайдын үеэр энэ Бямбацогт дарга бид нар ярьж байгаа ажлын хэсэг байгуулаад, энийг нь би бас ахлаад, ингээд Төрийн байгуулалтын байнгын хороо Нямаагийн Энхболд дарга байхдаа дэмжээд ингээд эхлээд дараа нь Лүндээ даргад энийг нь хүлээлгэж өгөөд ингээд цаашаа явсан ийм л юутай л даа.

Тэгээд би энэ Үндсэн хуулийн өөрчлөлтийг ажил болчихоосой гэж бодож байгаа. Ажил болохдоо ямар нэгэн хэл амгүй, дараа нь одоо дордуулсан 7 өөрчлөлт гэдэг шиг нэр хочгүй улс орныхоо нийгэм, эдийн засгийнхаа ирээдүйд янз бүрийн саар, саад болсон гэсэн ямар нэгэн ярлик, адрес байхгүйгээр энэ ирээдүйн Монгол Улсын сайн сайхны төлөө нэг ч гэсэн асуудлыг шийдсэн ийм Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт байгаасай л гэж хүсэж байгаа юм. Тэр утгаараа энэ нийгмийн зөвшилцлийн гэрээ гэдэг зарчмын үүднээсээ хандах нь зөв гэдэг байр суурийг би эхнээсээ барьж ирсэн.

Өнөөдөр Ерөнхийлөгчийн хориг ингээд ярьж байна. Энэний дараа одоо жишээлбэл бид нар энэ хоригийг хүлээж авахгүйгээр цаашаа явахад ямар эрсдэл үүсэх вэ гэхээр зэрэг зүгээр миний сая харснаар, сонссоноор бол жишээлбэл хугацаатай, хөрөнгөтэй холбоотой тогтоол батлагдахад дахиад хориг тавигдах эрсдэл өндөр байгаа юм байна.

Дахиад бид нар хориг яриад ингээд долоо, арван дөрөв хононо. Энэний дараа Үндсэн хуулийн цэц дээр очоод тэр 2013 оны гаргаж байсан шийдвэр, жишгийн дагуу цэцийн шийдвэр гарах эрсдэл өндөр байгаа юм. Ингээд явах юм бол Үндсэн хууль зөрчин зөрчин байж Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт

хийсэн гэдэг ийм нэг юм ингээд яригдаад явах ийм л нөхцөл байдал руу орох нь л дээ. Өнөөдөр парламентад гол хоёр суудлыг эзэлж байгаа Ардын нам, Ардчилсан намын зөвлөл. Ардын намын бүлэг энэ асуудлаа нэг яриад. Ерөнхийлөгчийн институттэйгээ нэг яриад ингээд цааш явах гарц боломж байгаа л гэж бодож байгаа.

Хоёрдугаар хэлэлцүүлгээ тодорхой хүрээнд яриад одоо задалдаг сан уу, гуравдугаар хэлэлцүүлгээ ярьж ойлголцоод цаашаа хийгээд явдаг сан уу. Тэгээд энэний үр дүнд бол яах вэ гэхээр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөс бол аль нэг улс төрийн хүчин, аль нэг улс төрч бол ашиг хонжоо харж хожно гэсэн ойлголт бол байхгүй шүү дээ. Энэ чинь мөнх биш шүү дээ. Хувь улс төрчийн цаг хугацаа, орон зай хязгаартай. Тэгээд нийгмийн одоо бүх энэ хуулиудыг ингэж зохицуулж байгаа нийгмийн гэрээний зөвшилцөл болж байгаа энэ том хуулийг бол хэл ам, хэрүүл маргаангүй цаашаа явах ёстой л гэж би ойлгож байгаа. Ерөнхийлөгчөөр ахлуулсан зөвшилцлийн ажлын хэсэг байгуулагдаад явж байхад би дотроо бол энэ асуудал ингээд ойлголцоод явах юм байна. Ерөнхийлөгчийн зүгээс хориг ирэхгүй юм байна гэж ойлгож байсан. Ардчилсан нам бүх ард нийтийн санал асуулгыг явуулах шаардлагыг Ардчилсан намын зөвлөлөөс өргөн барьж байхад Улсын Их Хурлаас бүх ард нийтийн санал асуулга явуулах шийдвэр гарахад энэ асуудлыг дэмжээд явах юм байна гэж ойлгож байсан. Гэтэл өнөөдөр ийм нэг ажин, түжин байдалд орчихлоо л доо.

Тийм учраас би Ерөнхийлөгчийн энэ хоригийг хүлээж авах нь зөв гэж бодож байгаа. Тэгээд эргээд одоо маргааш чуулган эхлэхээс өмнө өнөө оройдоо, маргаашдаа энэ асуудлуудаа эргэж ярилцаад тэгээд ямар боломж, гарц гаргалгаа байгаа. Цаашаа явах боломж, бололцоонууд гарц гаргалгаанууд бол зөндөө л байгаа шүү дээ. Тэгээд нэг нэр, хоёр хочгүй хаана хаанаа бухимдал, ажиг сэжиг байхгүй. Хар хоргүй нэг ийм Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хийгээд цаашаа Монгол Улсын дахиад нэг 20, 30 жилийн хөгжлийн шинэ түүхийг бичихэд хувь нэмэр оруулсан, үр дүнгээ өгсөн ийм л өөрчлөлт байгаасай л гэж ингэж ойлгож байгаа.

Тийм учраас Их Хурлын гишүүний хувьд бол энэ хоригийг хүлээж авна гэсэн ийм байр суурьтай байгаа гэдгээ хэлье. Ер нь бол бүгдээрээ хэлэлцвэл буруугүй, бүлээн усаар угаавал хиргүй гэдэг. Энэ бол аль нэг салбарын хууль биш. Аль нэг байгууллагын хууль биш. Аль нэг тухайн асуудлыг зохицуулж байгаа хууль биш. Энэ эцэг хуулийн тухай асуудал яригдаж байгаа энэ үед бол ингэж олон талын, олон ургалч үзлийн байр суурийг нэгтгэж, зангидаж цаашаа алхах нь зөв байх. Тэгэхгүй бол олон дараа дараагийн хур нүх, хэл ам, хэрүүл тэнцлийн бай болох юм байна гэж ингэж ойлгож байгаа.

С.Бямбацогт: Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Ард нийтийн санал асуулга явуулах Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн эхийг батлах тухай Улсын Их Хурлын 2019 оны 73 дугаар тогтоолд бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авах нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 38.5 хувийн саналаар хоригийг

хүлээж авахаар болж байна.

Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёр нь буюу 66.6 нь хоригийг хүлээж аваагүй бол Улсын Их Хурлын шийдвэр хүчин төгөлдөр үзнэ гэсэн байсан. Гуравны хоёроос сая гуравны нэгээс дээш нь хүлээж авахаар дүн гарлаа. Тэгээд 68.4 хувийн саналаар юу билээ, биш энэ чинь.

Тийм. 38.5 хувийн саналаар хориг хүлээн авагдаж байна.

Ингээд өнөөдрийн ард нийтийн санал асуулга явуулах тухай Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн эхийг батлах тухай Улсын Их Хурлын 2019 оны 73 дугаар тогтоолд бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооны санал дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Лүндээжанцан танилцуулна. Шаварт унасан, шарын эзэн хүчтэй. Та одоо асуултад хариул. Харин тэгээд. Санал дүгнэлтээ уншаад, асуултад хариул та. Тийм.

Тэгж байж танд асуултад хариулах боломж гарна шүү дээ. Тэгье. Тэгвэл Тогтохсүрэн дарга. Мөнхбат гишүүн.

Дууны бичлэгээс буулгасан:

Б.БААСАНЖАВ /Гэрээт/

Б.УРАНЧИМЭГ /Гэрээт/